

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тайлбарыг дараах байдлаар гаргав. Үүнд:

1.Нэмэлт, өөрчлөлт оруулах, өөрчлөн найруулах, үг өгүүлбэрийг хасах, хүчингүй болсонд тооцох болсон үндэслэл, шаардлага

Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйл, хэсэг	Үндэслэл, шаардлага
<b>1 дүгээр зүйл буюу Хууль тогтоомжийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмэх болсон үндэслэл, шаардлагын талаар</b>	
<b>1/4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт:</b> “4.1.1.хүний эрх, эрх чөлөөг хангах хууль зүйн баталгааг бүрдүүлэх;”	Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан тул аливаа хууль тогтоомжийн төсөл энэхүү шаардлагад нийцэх ёстой гэж үзсэн.
<b>2/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:</b> “12.4.Энэ хуулийн 12.1.3, 12.1.6-д заасан аргачлал нь Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахад хамаарахгүй.”	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33.1-д зааснаар үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлдэг тул уг хэрэгцээ шаардлагыг 12.1.2-т заасны дагуу тандан судалсны дагуу тодорхойлох ёстой гэж үзсэн.
<b>3/15 дугаар зүйлийн 15.13 дахь хэсэг:</b>  “15.13.Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд баталсан огноог тусгана.”	Хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалд холбогдох хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр тусгах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах үе шатны ажиллагаанд ахиц гарна гэж үзсэн.

<p><b>4/17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэг:</b> “17.3.Тухайн хуулийн төслөөр хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг хангасан эсэхийг энэ хуулийн 17.2.4-т заасан үнэлгээнд нэмж тусгана:</p> <p>17.3.1.үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн хэв журмыг хамгаалах зайлшгүй шаардлага бүхий байх;</p> <p>17.3.2.нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн байх;</p> <p>17.3.3.ялгаварлан гадуурхаагүй, жендэрийн мэдрэмжтэй байх;</p> <p>17.3.4.хязгаарлалтыг боломжит хамгийн бага түвшинд тогтоосон байх.”</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.”, 3 дахь хэсэгт “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.” гэж заасантай уялдуулсан.</p> <p>Монгол Улсын нэгдэн орсон хүний эрхийн олон улсын суурь гэрээнүүдэд заасан шаардлагад нийцүүлсэн.</p>
<p><b>5/18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсэг:</b> “18.3.Улсын Их Хурлын гишүүний санаачилсан хууль тогтоомжийн төсөлд Улсын Их Хурлын Тамгын газар, эсхүл судалгаа, шинжилгээний байгууллага, судлаач энэ хуулийн 18.1-д заасан зардлын тооцоог хийнэ.”</p>	<p>Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт зааснаар Улсын Их Хурлын үйл ажиллагаанд мэргэжил, арга зүй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх, ажиллах нөхцөлөөр хангах, хуульд заасан бусад ажлыг эрхэл үүрэг бүхий Тамгын газар ажиллахаар заасан.</p> <p>Бусад улс орнуудын нийтлэг туршлагаас үзвэл Австралийн холбооны улсад Хууль зүйн яам, Парламентын Төсвийн Оффис, Төсвийн төлөвлөлт, судалгааны агентлагууд болон мэргэжилтнүүд хамтран хэрэгжүүлдэг, БНСУ-д Үндэсний Ассамблейн Төсвийн бодлогын газар нь улсын төсвийн тооцоо, санхүү, санхүүгийн удирдлага, сангийн үйл ажиллагаатай холбоотой хуулийн төслүүдэд зардлын тооцоо хийх үүргийг гүйцэтгэдэг байна.</p>
<p><b>6/27<sup>1</sup> дүгээр зүйл: “27<sup>1</sup> дугаар зүйл.Захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгосон хуулийн төслийн зохицуулалтад тавигдах шаардлага</b></p>	<p>Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны хэм хэмжээний акт гаргахад тавигдах нийтлэг шалгуурыг тогтоосон бөгөөд үүнийг Хууль тогтоомжийн тухай</p>

<p>27<sup>1</sup>.1.Хуулийн төсөлд захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалт тусгахад дараах шаардлагыг хангана:</p> <p>27<sup>1</sup>.1.1.хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авахад чиглэсэн байх;</p> <p>27<sup>1</sup>.1.2.тухайн хуулийн зорилго, зорилтод нийцсэн байх;</p> <p>27<sup>1</sup>.1.3.захиргааны хэм хэмжээний акт батлахад баримтлах тухайлсан зарчмыг тодорхойлсон байх;</p> <p>27<sup>1</sup>.1.4.зорилго, зохицуулах харилцааны хүрээг тодорхой тусгасан байх;</p> <p>27<sup>1</sup>.1.5.захиргааны хэм хэмжээний акт батлах байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон, тухайн этгээдийн хуульд заасан үндсэн чиг үүрэгт хамааралтай байх;</p> <p>27<sup>1</sup>.1.6.хуулиар тогтоосон иргэн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулаагүй байх.</p> <p>27<sup>1</sup>.2.Захиргааны хэм хэмжээний акт батлах эрх олгосон зохицуулалтад дараах асуудлыг тусгахгүй:</p> <p>27<sup>1</sup>.2.1.Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах, хариуцлага оногдуулах асуудал;</p> <p>27<sup>1</sup>.2.2.Монгол Улсын Үндсэн хуульд гагцхүү хуулиар зохицуулахаар заасан аливаа төрлийн харилцаа;</p>	<p>хуультай уялдуулах шаардлагатай гэж үзсэн.</p> <p>Учир нь хуулиар тухайн хуулийн тодорхой зүйл, хэсэг, заалтыг хэрэгжүүлэх зорилгоор эрх олгосон тохиолдолд захиргааны хэм хэмжээний акт батлан гаргадаг байх, ийнхүү гаргах тохиолдолд тухайн эрх олгосон заалтад ямар агуулгыг тусгахыг тодорхойлсноор хуулиас давсан бус, түүнд нийцсэн, хуулиар тогтоосон хүрээ хязгаарт нийцсэн акт гаргах боломж бүрдэнэ гэж үзсэн.</p>
--	--

<p>27<sup>1</sup>.2.3.албан татвар, төлбөр, хураамж тогтоосон харилцаа;</p> <p>27<sup>1</sup>.2.4.эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа тогтоох асуудал;</p> <p>27<sup>1</sup>.2.5.гомдол, маргааныг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журам тогтоох асуудал.</p> <p>27<sup>1</sup>.3.Захиргааны хэм хэмжээний акт гаргах хугацааг энэ хуулийн 27.1-д заасан хуулийг дагаж мөрдөх журамд тусгана.”</p>	
<p><b>7/28 дугаар зүйлийн 28.3.6 дахь заалт:</b> “28.3.6.асуудал эрхэлсэн төрийн байгууллагын үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрх;”</p>	<p>Хүчин төгөлдөр үйлчилж буй Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төслийн бүтцийн дарааллыг тогтоосон бөгөөд тус хуулийн 28 дугаар зүйлийн 28.3.5-д иргэн, хуулийн этгээдээс үйл ажиллагаа явуулах журам, тэдгээрийн эрх үүргийг төрийн байгууллагын үйл ажиллагаа явуулах журам, бүрэн эрхийн зохицуулалтыг тусгахын өмнө тодорхойлж тусгах нь зөв гэж үзсэн.</p>
<p><b>8/29 дүгээр зүйлийн 29.5 дахь хэсэг:</b> “29.5.Энэ хуулийн 12.2.2-т заасан хуулийн төслийг дагалдуулан бусад хууль тогтоомжийн төсөл өргөн мэдүүлэх тохиолдолд тухайн төслөөр зөвхөн төсөв, санхүүгийн харилцааг зохицуулна.”</p>	<p>Улсын төсөв, түүнд оруулах тодотголын төслийг өргөн мэдүүлэхдээ зөвхөн төсөв, санхүүгийн харилцааг зохицуулах зорилгоор бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулах нь хууль тогтоомжийн нийцлийг хангах, улмаар Хууль тогтоомжийн тухай хуулийн 2.1.3-т зааснаар хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан байх зохицуулалтыг хэрэгжүүлэхэд ахиц дэвшил авчирна гэж үзэв.</p>
<p><b>9/33 дугаар зүйлийн 33.3.3, 33.3.4 дэх заалт:</b></p> <p>“33.3.3.холбогдох төрийн байгууллага, иргэд, олон нийтээс хуулийн төсөлд өгсөн саналын товъёг, тухайн саналыг хуулийн төсөлд</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн зорилго нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахад чиглэдэг ба уг хуулийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах нийтлэг зарчмыг баримтлахаар зохицуулсан.</p>

<p>тусгасан, эс тусгасан талаарх нэг бүрчилсэн тайлбар, үндэслэл;</p> <p>33.3.4.тухайн хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан гадаад орны хууль тогтоомжийн зохицуулалтад харьцуулалт хийж, тусгасан тохиолдолд тэдгээрийн талаарх тайлбар, дүгнэлт;”</p>	<p>Хуулийн энэхүү нийтлэг зарчмыг хангах хүрээнд холбогдох төрийн байгууллага, иргэд, олон нийтээс хуулийн төсөлд өгсөн саналын товьёг, тухайн саналыг хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх нэг бүрчилсэн тайлбар, үндэслэлийг хуулийн төслийн танилцуулгад тусгаж байх нь хууль тогоомжийн төслийг өргөн мэдүүлсний дараа Улсын Их Хурлын Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах, төслийн хэлэлцүүлэг ил тод, нээлттэй явагдах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзсэн болно. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах зарчмын хэрэгжилт хангагдана.</p>
<p><b>10/38 дугаар зүйлийн 38.10 дахь хэсэг:</b> “38.10.Хууль санаачлагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс энэ хуулийн 38.6.1, 38.6.2-д заасан хэлбэрээр санал авч хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”</p>	<p>Хууль санаачлагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс санал авахдаа заавал ашиглах арга хэлбэрт бичгээр саналыг нь авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах асуудлыг үүрэгжүүлсэн. Ингэснээр эдгээр этгээдээс өгсөн санал хуулийн төсөлд хэрхэн туссан, эс туссаныг өргөн мэдүүлсний дараа хэлэлцүүлгийн шатанд анхаарах боломж бүрдэнэ.</p>
<p><b>11/39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг:</b> “39.3.Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх зохицуулалт бүхий хуулийн төсөлд Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг заавал авсан байна.”</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлана.</p> <p>Хууль санаачлагчийн зүгээс ийнхүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан хуулийн төсөл санаачлан боловсруулах тохиолдолд хууль хэрэглэх эрх бүхий этгээд болох Улсын дээд шүүх, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий төрийн байгууллагууд Улсын ерөнхий прокурор, Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг заавал авсан байхаар зохицуулав.</p>
<p><b>12/40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт:</b> “40.1.3.хууль тогтоомжийн төслийн энэ хуулийн 33 дугаар зүйлд заасан</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төслийн танилцуулгад холбогдох төрийн байгууллага, иргэд, олон нийтээс хуулийн төсөлд өгсөн саналын товьёг, тухайн саналыг хуулийн төсөлд тусгасан, эс</p>

шаардлагыг хангасан товч болон дэлгэрэнгүй танилцуулга;	тусгасан талаарх нэг бүрчилсэн тайлбар, үндэслэл, тухайн хууль тогтоомжийн төсөлтэй холбогдуулан гадаад орны хууль тогтоомжийн зохицуулалтад харьцуулалт хийсэн тохиолдолд тэдгээрийн талаарх шинжлэх ухааны дүгнэлт, тайлбар зэргийг заавал тусгах зохицуулалтыг шинээр оруулж байгаатай холбогдуулан хуульд заасан шаардлага хангасан хуулийн төслийн товч болон дэлгэрэнгүй танилцуулгыг хуулийн төслийн бүрдүүлбэрт тусгахаар зохицуулсан.
<b>13/40 дүгээр зүйлийн 40.1.11, 40.1.12 дахь заалт:</b>  “40.1.11.энэ хуулийн 13.2.6-д заасан судалгааны тайлан;  40.1.12.энэ хуулийн 27 <sup>1</sup> .1-д заасны дагуу гаргах захиргааны хэм хэмжээний актын жагсаалт, 27 <sup>1</sup> .3-т заасан мэдээлэл”	Хэрэв хууль санаачлагч гадаад улс орнуудын хуулийн харьцуулсан судалгааг хийсэн бол тухайн судалгааны тайланг хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргахаар, мөн тухайн хуулийн төслөөр захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх олгосон зохицуулалт тусгагдаж байгаа тохиолдолд хуулийн төслийн бүрдүүлбэрт тухайн эрх олгосон зохицуулалтын дагуу эрх бүхий этгээдээс батлан гаргах шаардлагатай захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг цуг гаргаж байх шаардлагыг нэмэлтээр оруулсан.
<b>14/41 дүгээр зүйлийн 41.3.6 дахь заалт:</b> “41.3.6.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.15-д заасан хугацааг хангасан эсэх.”	2024 оноос хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 36.15-д Улсын Их Хурал тодорхой хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг олон улсын нийтлэг жишиг, Ром-Германы эрх зүйн тогтолцоотой улс орнуудын парламентын хуралдааны дэгийн тухай хуулийн туршлагаас харгалзан тусгасан. Энэхүү зохицуулалтыг хэрэгжүүлэх хүрээнд өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг шалгахдаа харгалзан үзэхээр зохицуулсан.
<b>15/41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг:</b>  “41.4.Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны асуудал эрхэлсэн хүрээлэн энэ хуулийн 17.2.4-т заасан	Австралид шинээр боловсруулсан хуулийн төслийг хүний эрхэд үзүүлэх нөлөөллийг үнэлэх үйл явц нь хүний эрхийн нийцэл, үндсэн хуулийн шаардлагууд, олон улсын гэрээнүүдтэй нийцэх эсэх, хүний эрхийн

<p>хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээ аргачлал, энэ хуулийн 17.3-т заасны дагуу хийгдсэн эсэхэд ажлын 5 өдрийн дотор дүгнэлт гаргана.”</p>	<p>дүгнэлт болон олон талт зөвшилцөл дээр тулгуурласан байдаг. Энэ үнэлгээний гол зорилго нь хуулийн төсөл хүний эрхийг зөрчихгүй, ялангуяа хамгийн эмзэг бүлгүүдийг хамгаалахад чиглэгдсэн зохицуулалтыг бий болгох явдал байдаг бол БНСУ-д Засгийн газраас хуулийн төсөл боловсруулах үе шатанд хуулийн төсөл дэх төрийн болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагын тодорхой захиргааны зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ард иргэдийн эрхийг хязгаарласан эсхүл үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг Зохицуулалт шинэтгэлийн хороогоор хянуулдаг байна. Ард иргэдийн эрхийг хязгаарласан, үүргийг чангатгасан зохицуулалтыг заавал Хороогоор хянуулах ба хуулийн төслийг Засгийн газрын хууль тогтоомжийн газар хянаж, Засгийн Газрын Хуралдаанд мэдүүлэх үед тус хорооны хяналтын дүгнэлтийг хавсаргах ёстой байдаг. Хууль тогтоомжийн тухай хуульд 2023 онд оруулсан нэмэлтээр хуулийн төслийн үр нөлөөг үнэлх ажлын хүрээнд хүний эрхэд нөлөөлөх байдлыг давхар үнэлж байх зохицуулалт тусгагдсан. Энэхүү үнэлгээ аргачлалын дагуу хийгдсэн эсэхэд хуулийн төслийг өргөн мэдүүлэхээр ирүүлсний дараа төслийн бүрдүүлбэрийг хянах ажлын хүрээнд давхар нягтлан шалгаж байх чиг үүргийг тусгах нь зүйтэй гэж үзэв.</p>
<p><b>16/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг:</b></p> <p>“44.3.Холбогдох төрийн байгууллага нь хүний хувийн мэдээлэл, төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах нөхцлийг бүрдүүлнэ.”</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн албан ёсны эхээс хуулбарласан хувийг холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийн санг бүрдүүлэхээр тусгасан. Холбогдох төрийн байгууллагын бүрдүүлсэн хууль тогтоомжийн сан дахь хууль тогтоомжийн хувийн хэрэгтэй иргэд, олон нийт чөлөөтэй танилцах нөхцлийг бүрдүүлэхээр төсөлд тусгав.</p>
<p><b>17/45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсэг:</b></p>	<p>Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын</p>

<p>“45.5.Хууль тогтоомжийн цахим сан нь хөгжлийн бэрхшээлтэй хүн онцлог хэрэгцээнд тохирсон хэлбэрээр ашиглах боломжтой байна.”</p>	<p>адил хүний үндсэн эрх, эрх чөлөөг тэгш эдлэхэд зориулсан нэн хэрэгцээтэй тоног төхөөрөмж, материал, хэрэгсэл, программ хангамж, орчин нөхцөл, үйлчилгээ буюу тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах эрхтэй гэж заасан. Түүнчлэн тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.6-д зааснаар хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй холбоотой төрийн бодлого, шийдвэрийг боловсруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үйл ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн бус байгууллагын төлөөллийн оролцоог хангах үндсэн зарчмыг баримтлахаар заасан.</p> <p>Тус хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Мэдээллээр үйлчилдэг хуулийн этгээд нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хөгжлийн бэрхшээлтэй хүний мэдээлэл авах эрхийг хангах, техник, технологийн хэрэгсэл, бусадтай харьцах боломж, нөхцөлийг бүрдүүлнэ.” гэсэн ба мөн зүйлийн 11.2.1-т “төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох;”-ыг үүрэг болгосон.</p>
<p><b>18/51 дүгээр зүйлийн 51.5, 51.6 дахь хэсэг:</b></p> <p>“51.5.Тав ба түүнээс дээш жил дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд биелэлтийн үр дагаврын үнэлгээг хийж, энэ хуулийн 52 дугаар зүйлд заасны дагуу үнэлгээний үр дүнг хэлэлцүүлсэн байна.</p> <p>51.6.Энэ хуулийн 49.1, 49.2-т заасан этгээд хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.”</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр зохицуулсан. Тус хуулиар шаардлагатай тохиололд уг хугацаанаас өмнө хийж болохоор мөн тусгасан.</p> <p>Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд МУИС-ийн Хууль зүйн сургуулиар хийлгэсэн хууль тогтоомжийн хэрэгжлтийн үр дагаврын судалгаанд дурдсанаар: “Хууль тогтоомжийн тухай хуулийг 2015 оны 5 дугаар сарын 29-ний өдөр батлаж, улмаар 2017 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - Легалинфогоос шүүлт хийхэд 2017 оноос хойш батлагдсан 140 хууль байна. 2017 оноос хойш дагаж мөрдөж буй 140 хуульд</p>

	<p>хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийгдсэн эсэхийг шалгахад дараах үр дүн харагдаж байна. ХТтХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.3 дахь хэсэгт зааснаар Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн эрх зүйн салбарын нийтлэг харилцаа”-д хамаарах чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлгээг хэрэгжүүлдэг. Хууль зүйн үндэсний хүрээлэн нь 2016-2023 онд 35 [хүчин төгөлдөр] хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийсэн байна. Эндээс 2017 оноос хойш дагаж мөрдөж буй ямар хуулиудад ийм судалгаа хийгдсэн байна вэ гэдгийг нягтлан үзэхэд Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль гэсэн 4 хуулийн хэрэгжилтэд үр дагаврын үнэлгээг хийсэн байна (ЗГ-ын 2006 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу). Өөрөөр хэлбэл Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хийсэн хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний дийлэнх хэсгийг 2017 оноос хойш дагаж мөрдөж буй гэхээсээ үүнээс өмнө хүчин төгөлдөр болж үйлчилэн буй хуулиуд эзлэж байна.” гэжээ.</p> <p>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж ажил хангалтгүй байгаад дүгнэлт хийж, цаашид тав ба түүнээс дээш жил дагаж мөрдөж байгаа хууль тогтоомжийг шинэчлэн найруулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд биелэлтийн үр дагаврын үнэлгээг хийж, үнэлгээний үр дүнг Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хэлэлцүүлсэн байх шаардлагыг нэмж тусгав.</p>
<b>2 дугаар зүйл буюу Хууль тогтоомжийн тухай хуульд оруулсан бусад нэмэлтийн үндэслэл, шаардлагын талаар</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсгийн “үр нөлөөг” гэсний дараа “шалгуур үзүүлэлтийг сонгох, хуулийн	Хууль тогтоомжийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан нь хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хууль

<p>төслөөс үр нөлөөг тооцох хэсгийг сонгох, үр нөлөөг тооцох, үр дүнг үнэлж зөвлөмж өгөх үе шаттайгаар” гэж, 21 дүгээр зүйлийн 21.9.1 дэх заалтын “нийцэж байгаа эсэх” гэсний дараа “, түүний үзэл баримтлалыг бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг дэмжиж байгаа эсэх үндэслэл, тайлбар” гэж, мөн зүйлийн 21.13 дахь хэсгийн “бодлогод нийцээгүй,” гэсний дараа “тухайн хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг бүхэлд нь дэмжих боломжгүй,” гэж, 28 дугаар зүйлийн 28.1.1 болон 28.3.1 дэх заалтын “гарчиг” гэсний дараа “, бүлэг, дэд бүлэг, зүйлийн товъёг” гэж, 28.3.3 дахь заалтын “нэр томъёоны тайлбар” гэсний өмнө “цагаан толгойн үсгийн дарааллаар жагсаасан” гэж, 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “боловсруулна” гэсний урд “анх батлагдсан хууль болон дагалдаж буй хуулийн төслийн үзэл баримтлал, агуулгад нийцүүлэн” гэж, 33.3.3 дахь заалтын “ухагдахууны үүсэл” гэсний дараа “, нэр томъёог нийцүүлсэн талаарх тайлбар” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “цахим хуудсандаа” гэсний ард “болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд” гэж, 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсгийн “39.3” гэсний дараа “, 39.4” гэж, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь хэсгийн “энэ хуулийн 41.3” гэсний дараа “, 41.4” гэж, 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсгийн “байршуулах бөгөөд” гэсний ард “хууль тогтоомжийн “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувь, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланг хавсаргана. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн” гэж тус тус нэмсүгэй.</p>	<p>тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх, уялдааг шалгах боломжтой мэдээллийн шинэ технологид тулгуурласан шийдэл бүхий байна.” гэж заасан. Эрх зүйн мэдээллийн нэгсдэн сан буюу <a href="http://www.legalinfo.mn">www.legalinfo.mn</a> цахим сангийн өнөөдөр ажиллаж буй байдлыг хэрэглэгчийн үүднээс харвал энэ хэсэгт заасан “хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх, уялдааг шалгах” мэдээллийн технологийн шийдэлд тулгуурласан гэж одоогоор үзэх боломжгүй байна. Энэхүү заалтын хэрэгжилтийг хангах, цаашид хууль тогтоомжийн сангаас иргэд, олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор зарим зохицуулалтыг хуулийн төсөлд нэмж тусгав. Тухайлбал уг санд хууль тогтоомжийн “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн эх хувь, түүний үзэл баримтлал, хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлтийн түүх, хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээний тайланг хавсаргахаар зохицуулав.</p>
--	--

<b>3 дугаар зүйл буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах үндэслэл, шаардлагын талаар</b>	
<b>1/7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг:</b>  “7.5.Үндсэн чиглэлд тусгагдсан хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн тохиолдолд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт, дэс дарааллыг тогтоохдоо харгалзан үзнэ.”	Хууль тогтоомжийн тухай хуулийн одоогийн заалтыг буюу 7.5 дахь хэсгийн заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хэн ч халдаж үл болно. Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиас бусад хуулиар зохицуулахыг хориглоно.” гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна.” гэж заасантай нийцүүлсэн.
<b>2/13 дугаар зүйлийн 13.2.6 дахь заалт:</b>  “13.2.6.шаардлагатай тохиолдолд тухайн асуудлаар бусад улсын эрх зүйн зохицуулалтын талаархи харьцуулсан судалгааг үндэсний эрх зүйн тогтолцооны уламжлал, онцлог, хөгжлийн чиг хандлага болон эрх зүйн бүл, соёлын төсөөтэй, ялгаатай байдлыг харгалзан, үндэсний ашиг сонирхолд нийцүүлэх зарчимд тулгуурлан хийх.”	Энэ хуулийн төсөлд тусгагдсан бусад зохицуулалттай нийцүүлэх зорилгоор боловсруулсан.
<b>3/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:</b>  “17.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг судалгаа, шинжилгээний байгууллага, судлаачаар энэ хуулийн	Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээг мэргэжлийн судалгааны этгээд гүйцэтгүүлэхээр тусгасан нь хууль санаачлагчийн хууль санаачлах бүрэн эрхийг бүрэн утгаар хангахад чиглэсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн 2 дугаар

12.1.3-т заасан аргачлалын дагуу гүйцэтгүүлнэ.”	зүйлийн 2.1.2-т “хууль санаачлах эрх” гэж хууль санаачлагчаас мэргэжлийн түвшинд боловсруулж, өргөн мэдүүлэхийг хэлэхээр зохицуулсан.
<p><b>4/18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг:</b></p> <p>“18.1.Хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг баталснаар үүсэх зардлын тооцоог гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу дараах байдлаар үнэлж, тодорхойлно:</p> <p>18.1.1.хууль тогтоомжийн төслийн улсын төсөвт үзүүлэх нөлөөллийг тооцох;</p> <p>18.1.2.хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцох;</p> <p>18.1.3. хууль тогтоомжийн төслийг батлан хэрэгжүүлснээр эдийн засагт үзүүлэх нөлөөллийг үнэлэх.”</p>	Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг илүү өргөн хүрээнд буюу төсөв, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл, хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг тооцохоор тусгав.
<p><b>5/38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг:</b></p> <p>“38.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хууль санаачлагч хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээс өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл, олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох материалыг баримтжуулан хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрт хавсаргана.”</p>	Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөллөөс санал авах үйл ажиллагааг тодотгосон.
<p><b>6/38 дугаар зүйлийн 38.7 дахь хэсэг:</b></p> <p>“38.7.Хууль санаачлагч олон нийтийн хэлэлцүүлгийн хугацаа дууссан өдрөөс хойш 30 хоногийн дотор хуулийн төсөлд тусгасан болон тусгаагүй саналын товъёгийг бэлтгэн</p>	Хууль тогтоомжийн тухай хуулийн зорилго нь хууль тогтоомжийн төсөл боловсруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангахад чиглэдэг ба уг хуулийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог хангах нийтлэг зарчмыг баримтлахаар зохицуулсан.

<p>албан ёсны цахим хуудсандаа болон хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим системд байршуулна. Хууль тогтоомжийн төсөлд санал авах нэгдсэн цахим систем нь энэ хуулийн 45.3-т заасан эрх зүйн мэдээллийн нэгдсэн сангийн нэг бүрэлдэхүүн байна.”</p>	<p>Хуулийн энэхүү нийтлэг зарчмыг хангах хүрээнд холбогдох төрийн байгууллага, иргэд, олон нийтээс хуулийн төсөлд өгсөн саналын товьёг, тухайн саналыг хуулийн төсөлд тусгасан, эс тусгасан талаарх нэг бүрчилсэн тайлбар, үндэслэлийг хуулийн төслийн танилцуулгад тусгаж байх нь хууль тогоомжийн төслийг өргөн мэдүүлсний дараа Улсын Их Хурлын Байнгын хороо, чуулганы нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийг үр дүнтэй явуулах, төслийн хэлэлцүүлэг ил тод, нээлттэй явагдах нөхцлийг бүрдүүлнэ гэж үзсэн болно. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийг судалгаа, шинжилгээнд үндэслэн боловсруулах зарчмын хэрэгжилт хангагдана.</p>
<p><b>7/40 дүгээр зүйлийн 40.3 дахь хэсэг:</b></p> <p>“40.3.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 63.1, 65.1-д заасан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, мөн хуулийн 115 дугаар зүйлд заасан тайлан, илтгэл нь энэ хуулийн 40.2-т заасан шаардлагыг хангасан байна.”</p>	<p>Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийн заалттай нийцүүлсэн. Тодруулбал, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад заасны дагуу боловсруулж, хэлэлцүүлэх бодлогын баримт бичгийн нэршилтэй нийцүүлсэн. Тодруулбал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиудад заасан тайлан, илтгэл нь албан хэрэг хөтлөлтийн нийтлэг шаардлагыг хангасан байхыг зохицуулж өгсөн.</p>
<p><b>8/49 дүгээр зүйлийн 49.1, 49.2 дахь хэсэг:</b></p> <p>“49.1.Дараах хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороо, Улсын Их Хурлын Тамгын газар болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг холбогдох байгууллага хэрэгжүүлнэ:</p> <p>49.1.1.Улсын Их Хурлын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл</p>	<p>Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг ямар хуулиад хийх хүрээ, хязгаарыг тодорхой болгосноор хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ тогтмолжиж, хуулийн хэрэгжилт сайжирна гэж үзсэн.</p>

<p>ажиллагааны журмыг зохицуулж буй хууль тогтоомж;</p> <p>49.1.2.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын бүтэц, бүрэлдэхүүн, үйл ажиллагааны журмыг зохицуулж буй хууль тогтоомж.</p> <p>49.2.Энэ хуулийн 49.1, 49.3-т зааснаас бусад хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаврын үнэлгээг Засгийн газраас үүрэг болгосны дагуу холбогдох төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.”</p>	
<p><b>4 дүгээр зүйл буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн бусад зүйл, хэсэг, заалтыг өөрчлөн найруулах үндэслэл, шаардлагын талаар</b></p>	
<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-4.1.4 дэх заалтын дугаарыг “4.1.2-4.1.5” гэж, 17.3 дахь хэсгийн дугаарыг 17.4 гэж, 28.3.6-28.3.10 дахь заалтын дугаарыг “28.3.7-28.3.11” гэж, 33.3.3 дахь заалтын дугаарыг “33.3.5” гэж, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсгийн “хавсаргана” гэснийг “энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангуулж хавсаргана” гэж, 39 дүгээр зүйлийн 39.3, 39.4 дэх хэсгийн дугаарыг “39.4, 39.5” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1.3, 40.1.4 дэх заалтын дугаарыг “40.1.4, 40.1.5” гэж, 41 дүгээр зүйлийн 41.2 дахь хэсгийн “хянана” гэснийг “хянах бөгөөд төслийн бүрдүүлбэрийг хянах хуудсыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батална.” гэж, мөн зүйлийн 41.4, 41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10 дахь хэсгийн дугаарыг “41.5, 41.6, 41.7, 41.8, 41.9, 41.10, 41.11” гэж, 41.5 дахь хэсгийн “41.4-д” гэснийг “41.5-д” гэж, 41.7 дахь хэсгийн “41.5-д” гэснийг “41.6-д” гэж, 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийн “гэрээний” гэснийг “гэрээ, түүний хянан баталгаажуулсан монгол хэл дээрх орчуулга, англи хэл дээрх эх бичвэрийн” гэж, 44 дүгээр зүйлийн 44.3</p>	<p>Хууль тогтоомжийн тухай хуулийн бусад зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан нэр томъёог жигдлэх, зүйл, заалтын дугаарлалтыг нийцүүлэх өөрчлөлтийг тусгасан.</p>

дахь хэсгийн дугаарыг “44.4” гэж тус тус өөрчилсүгэй.	
<b>5 дугаар зүйл буюу Хууль тогтоомжийн тухай хуулийн зарим заалтыг хасах үндэслэл, шаардлагын талаар</b>	
Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.17, 12.2.24 дэх заалтыг, 15.7.1 дэх заалтын “иргэн, захиргаа,” гэснийг, 28.3.9, 28.8.6 дахь заалтын “шаардлагатай бол” гэснийг, 38 дугаар зүйлийн 38.9 дэх хэсгийн “12.2.1,”, “, 12.2.23, 12.2.24” гэснийг, 40 дүгээр зүйлийн 40.1.2 дахь заалтын “товч болон дэлгэрэнгүй танилцуулга,” гэснийг тус тус хассугай.	Хууль тогтоомжийн тухай хуулийн бусад зүйл, хэсэг, заалтуудад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулгад нийцүүлсэн.

2.Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалт нь Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалд тусгагдсан бөгөөд үзэл баримтлалын хүрээнээс гажаагүй болно.

3.Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд шинэ нэр томьёо, ухагдахуун оруулаагүй бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэж уг хуулийн төслийг боловсруулсан болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

--oOo--